

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ АРАВДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны гуравдугаар сарын 19-ний 14 цаг 05 минутад эхэлж, 15 цаг 09 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 04 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Төрийн албаны зөвлөлийн зарим Салбар зөвлөлийн даргыг томилох тухай</p> <ul style="list-style-type: none"><li>- Хүнс, хөдөө аж ахуйн яамны дэргэдэх салбар зөвлөлийн даргыг томилох</li><li>- Зам тээврийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн даргыг томилох</li><li>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргыг томилох</li><li>- Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргыг томилох</li></ul>	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 01/635 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <ol style="list-style-type: none"><li>1. Төрийн албаны зөвлөлийн Хүнс, хөдөө аж ахуйн яамны дэргэдэх салбар зөвлөлийн даргаар тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Намсрайн Ариунболдыг 2015 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн томилох.</li><li>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын нэгийн 10-т "Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга-яамны Төрийн нарийн бичгийн дарга Хадбаатарын Золжаргал" гэснийг "Хүнс, хөдөө аж ахуйн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга -яамны Төрийн нарийн бичгийн дарга Намсрайн Ариунболд" гэж өөрчлөх</li><li>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга Н.Ариунболдод үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн</li></ol>

		<p>албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, Зам, тээврийн сайдын 2015 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 1/922 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Зам, тээврийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн даргаар тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Жалавсүрэнгийн Бат-Эрдэнийг 2015 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн томилох.</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын "Нэг"-ийн 6-д "....Баасандоржийн Батзаяа" гэснийг "....Жалавсүрэнгийн Бат-Эрдэнэ" гэж өөрчлөх</p> <p>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга Ж.Бат-Эрдэнэд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд даргын 2015 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 02/865 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргаар тус газрын дарга Баянмөнхийн Билэгтийг 2015 оны 03 дугаар сарын 20-</p>
--	--	--

	<p>ны өдрөөс эхлэн томилох</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын хоёрын 6-д “хурандаа Далайхүүгийн Ядамдорж” гэснийг “бригадын генерал Баянмөнхийн Билэгт” гэж өөрчлөх</p> <p>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга Баянмөнхийн Билэгтэд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргаар тус газрын дарга Рэнцэндоржийн Чингисийг 2015 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн томилох</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын “Хоёр”-ын 3-т “.....бригадын генерал Баянмөнхийн Билэгт” гэснийг “....тэргүүн комиссар Рэнцэндоржийн Чингис” гэж өөрчлөх.</p> <p>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга Р.Чингист үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--

<p>2</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн зарим Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүнс, хөдөө аж ахуйн яамны дэргэдэх салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох</li> <li>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох</li> </ul>	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 1/635 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Төрийн албаны зөвлөлийн Хүнс, хөдөө аж ахуйн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөц, шагналын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Мандахын Чулуунцэцэгийг 2015 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн томилох</li> <li>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын нэгийн 10-т “...хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Рагчаабазарын Өнөрсайхан” гэснийг “...Хүний нөөц, шагналын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Мандахын Чулуунцэцэг” гэж өөрчлөх</li> <li>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга М.Чулуунцэцэгт үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</li> </ol> <p>Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилогдохоор нэр дэвшиж байгаа ахлах мэргэжилтэн Г.Баярхүү төрийн тусгай албаны шалгалт өгсөн эсэхийг тодруулах шаардлагатай тул уг асуудлыг хойшлуулахаар шийдвэрлэв.</p>
----------	--	---

<p>3</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.2, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг”-ийг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Нэг”-ийн 5-д “Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүн” гэсэн хэсгийг дараах байдлаар өөрчлөх. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Төрийн нарийн бичгийн дарга,</li> <li>2. Төрийн захиргааны удирдлагын газрын дарга,</li> <li>3. Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга,</li> <li>4. Барилга, нийтийн аж ахуйн бодлогын газрын дарга,</li> <li>5. Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын дарга,</li> <li>6. Барилгын чанар, аюулгүй ажиллагааны бодлогын газрын дарга,</li> <li>7. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дарга,</li> <li>8. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга,</li> <li>9. Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн</li> </ol> <p>тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
----------	--	--

<p>4</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн Аж үйлдвэрийн яамны дэргэдэх салбар зөвлөлийг байгуулах тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.2, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг”-ийг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Аж үйлдвэрийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийг 2015 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулах. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Төрийн нарийн бичгийн дарга,</li> <li>2. Төрийн захиргааны удирдлагын газрын дарга,</li> <li>3. Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга,</li> <li>4. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга,</li> <li>5. Хөнгөн үйлдвэрийн бодлого зохицуулалтын газрын дарга,</li> <li>6. Жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга,</li> <li>7. Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга,</li> <li>8. Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга,</li> <li>9. Төрийн захиргааны удирдлагын газрын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн.</li> </ol> <p>2. Аж үйлдвэрийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийг арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Орон тооны гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
----------	--	---

5	<p>Бусад асуудал /Булган аймгийн Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргуулах тухай/</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Лхагвадоржийн Батболдыг Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх</li> <li>2. Энэ тогтоолын нэгдүгээрт нэр заасан иргэн Лхагвадоржийн Батболдыг Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Булган аймгийн Засаг дарга Д.Эрдэнэбатад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</li> </ol>
---	--	---

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ